



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 04 өдөр

Дугаар АБЧ

Хэрлэн сум

Мал, амьтны гоц халдварт, халдварт  
өвчинтэй тэмцэх арга хэмжээг  
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4, 18.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Цэнхэрмандал суманд гахайн африкийн мялзан, Хэрлэн, Өмнөдэлгэр, Дархан суманд мал, амьтны галзуу, Баянмөнх суманд хорт салст халуурал өвчин оношлогдож хязгаарлалтын дэглэм тогтоон тэмцэх зааврыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба сар шинийн баяраар хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх тул дээрх голомтуудад золголтыг хязгаарлаж хөдөлгөөнд тавих хяналтыг чангатган, холбогдох байгууллагыг мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Дэглэм хэрэгжиж буй сумдын удирдлага, мэргэжилтнүүдийг арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Г Сүнгээ/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж шуурхай удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Н.Чанцал/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА